

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР  
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

ИЛТГЭХ ХУУДАС

Сумдын Засаг даргын Тамгын газрын 2020 оны ажил дүгнэж өгсөн зөвлөмжийн 2021 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийсэн тухай

2021.07.01

Мандалговь хот

Нэг: Хяналт- шинжилгээний зорилго

Сумдын Засаг даргын Тамгын газрын 2020 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлж үнэлгээний дүнг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан Зөвлөлийн хурлаас бүх сумдад нийтлэг хэрэгжүүлэх 20 заалт бүхий зөвлөмж, хяналт-шинжилгээний багаас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн явцтай танилцан зөвлөмжийн хэрэгжилтийн талаар аймаг, сумдын удирдлагуудыг мэдээллээр хангаж, зөвлөмжийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд хяналт-шинжилгээний зорилго оршино.

Хоёр. Хяналт- шинжилгээний үндэслэл, арга зүй

Сумдад өгсөн зөвлөмжийн 2021 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт – шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримталсан.


Хяналт-шинжилгээ хийх ажлын хүрээнд сумдуудаас ирүүлсэн тайланд үндэслэснээс гадна Шилэн данс хөтлөлтийг Санхүүгийн хяналт аудитын албаны мэдээлэл, Архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн зөвлөмжийн хэрэгжилтийг Хууль эрхзүйн хэлтсийн Архивын тасгийн мэдээлэл, Монгол хэл бичгийн сургалтын асуудлыг Боловсрол соёл урлагийн газрын мэдээлэл, Аж ахуйн нэгжийн тайлан гаргалтын байдлыг Санхүү төрийн сангийн хэлтсийн мэдээлэл, Засгийн газрын 2020 оны 216, 217, 218 тогтоолын цахим сургалтад хамрагдсан мэдээллийг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн мэдээлэл, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, аймгийн ИТХТ-ийн тогтоол, аймгийн Засаг даргын захирамжийн тухай суманд хамааралтай заалтыг хяналтад авч хэрэгжилт үр дүнг тооцсон байдал, аймгийн Засаг даргатай гэрээ байгуулсан гэрээний эхний хагас жилийн хэрэгжилтийг Төрийн захиргааны удирдлагын хэлтсээс ирүүлсэн мэдээлэл зэрэгт үндэслэн сумдуудаас нэмэлт мэдээлэл цуглуулах, тодруулга авах зэрэг аргаар хяналт-шинжилгээ хийсэн.

Гурав. Хяналт – шинжилгээ, үнэлгээний үр дүн

Зөвлөмжийн хэрэгжилтийг Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагааг тайлагнах хуваарийн дагуу сумдуудаас хүлээн авч хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийлээ. Зөвлөмжийн хэрэгжилтийг Адаацаг, Дэлгэрцогт, Луус, Сайхан-овоо, Сайнцагаан, Эрдэнэдалай сумдууд хугацаандаа, бусад 9 сум 2-7 хоногоор хугацаа хоцроож ирүүлсэн байна.

Зөвлөмжийн хэрэгжилтийн дундаж 62.1 хувь.

### Зөвлөмжийн хэрэгжилтийг хүснэгтээр харуулбал:




Баянжаргалан, Дэлгэрцогт, Цагаандэлгэр сумдууд санаачлагатай ажиллаж, бусад сумдууд зөвлөмжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Сумдуудад хэрэгжиж байгаа үндэсний болон аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан батлуулсан боловч хагас жилээр явц үр дүнг тооцоогүй.

1. Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилтийн эхний хагас жилийн тайланг Адаацаг, Дэлгэрцогт, Хулд сумдууд хугацаандаа ирүүлж, бусад сумдууд хугацаа хоцроосон байна. Гэрээний үүргийн хэрэгжилтэд хэлтэс бүр хяналт шинжилгээ хийж үнэлгээний дүнг нэгтгэхэд 64.3 хувийн хэрэгжилттэй байна. Хэрэгжилтийн байдлыг хэлтэс тус бүрээр авч үзвэл:

№	Сумдын нэр	СТСХ	ТЗУХ	ХЭЗХ	ХОХБТХ	НБХ	ХШҮДАХ	дүн
1	Адаацаг	90	73.3	65.8	44.7	48.5	70.5	65.5
2	Баянжаргалан	80	80.7	66.9	61.2	57.5	78.2	70.7
3	Говь-Угтаал	80	51.4	48.1	61.0	47.9	66.1	59.1
4	Гурвансайхан	85	74.8	65.2	60.0	58.4	68.8	68.7
5	Дэрэн	85	77.8	82.2	69.4	56.4	67.5	73.0
6	Дэлгэрцогт	80	80.2	66.0	54.8	70.5	77.0	71.4
7	Дэлгэрхангай	85	62.8	42.6	33.0	30.2	55.1	51.4
8	Луус	85	70.1	56.1	38.2	49.8	65.7	60.8
9	Өлзийт			-	-	-		0.0
10	Өндөршил	90	73.2	59.1	61.2	57.7	69.0	68.4
11	Сайнцагаан	90	77.8	52.8	61.2	60.7	66.5	68.2
12	Сайхан-Овоо	80	69.0	60.4	51.6	48.8	63.6	62.2
13	Хулд	80	41.2	36.0	62.2	58.0	60.5	56.3
14	Цагаандэлгэр	80	74.6	64.7	41.8	53.1	74.0	64.7
15	Эрдэнэдалай	85	59.0	57.8	44.8	52.1	60.4	59.8
16	дүн	83.9	69.0	58.8	53.2	53.5	67.4	64.3

Сум бүрээр харуулбал:



2. Монгол Улсын ерөнхийлөгчийн 2018 оны 46 дугаар зарлигийн /Монгол бичгийн хэрэглээг эрчимжүүлэх тухай/ дагуу Монгол бичгийн анхан шатны болон дунд шатны сургалтад аймгийн хэмжээнд нийт 2117 албан хаагч хамрагдахаас 1292 албан хаагч хамрагдсан байна. /Боловсрол соёл урлагийн газрын мэдээгээр/

№	Сумын нэр	Хүний тоо	Анхан шат	Дунд шат	НЭГТГЭЛ		Хувь
			Хамрагдсан хүний тоо	Хамрагдсан хүний тоо	Хамрагдсан ТАХ-ийн тоо	Сургалтын дүн	
1	Сайнцагаан	642	254	55	309	15.50	48.13
2	Адаацаг	126	41	64	105	47.57	83.33
3	Баянжаргалан	93	5	5	10	9.58	10.75
4	Говь угтаал	110	71	20	91	31.07	82.73
5	Гурвансайхан	96	72	20	92	20.66	95.83
6	Дэлгэрхангай	137	42	18	60	14.64	43.80
7	Дэлгэрцогт	90	48	29	77	0	85.56
8	Луус	95	32	50	82	43.65	86.32
9	Сайхан-Овоо	98	20	10	30	6.6	30.61
10	Хулд	108	0	36	36	14.5	33.33
11	Цагаандэлгэр	80	18	46	64	17.74	80.00
12	Эрдэнэдалай	246	97	38	135	27.40	54.88
13	Өлзийт	96	60	2	62	23.51	64.58
14	Өндөршил	100	59	0	59	20.79	59.00
15	Дэрэн	107	35	45	80	59.70	74.77
		<b>2117</b>	<b>854</b>	<b>438</b>	<b>1292</b>	23.52	62.24

Сургалтад хамрагдаж байгаа байдлаас харахад: Адаацаг, Говь-Угтаал, Гурвансайхан, Дэлгэрцогт, Луус, Цагаандэлгэр зэрэг 6 сум хамрагдвал зохих албан хаагчдынхаа 80-аас дээш хувийг хамруулсан бол Баянжаргалан сум 10.7 хувийг хамруулсан нь хангалтгүй байна.



3.Архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн мөрөөр өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг Хууль эрх зүйн хэлтсийн Архивын тасагт Баянжаргалан, Дэлгэрцогт, Дэлгэрхангай, Өлзийт, Өндөршил сумдууд ирүүлээгүй байна.

Зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт ирүүлсэн байдлыг харуулбал:

№	Сум, байгууллагын нэр	Тайлан ирүүлсэн байдал /АЗД-ын 1/226 албан тоотын улсын үзлэгийн төлөвлөгөөний тайлан/	
		Ирүүлсэн/ хувь	Ирүүлээгүй
1	2	3	4
1	Адаацаг	82	
2	Баянжаргалан		-
3	Говь-угтаал	79	
4	Гурвансайхан	85	
5	Дэлгэрцогт		-
6	Дэлгэрхангай		-
7	Дэрэн	88	
8	Луус	71	
9	Өлзийт		-
10	Өндөршил		-
11	Сайхан-овоо	73	
12	Сайнцагаан	61	
13	Хулд	76	
14	Цагаандэлгэр	82	
15	Эрдэнэдалай	88	

4. Сумдын шилэн дансанд мэдээлэл оруулсан байдлыг 2021 оны эхний 5 сарын байдлаар харуулбал:

Сумдын нэр		Оруулах ёстой мэдээлэл	Хугацаанд нь оруулсан	Хугацаа хоцроосон
Адаацаг сум	481	475	439	36
Баянжаргалан сум	481	427	394	33
Говь-Угтаал сум	421	390	387	3
Гурвансайхан сум	481	470	440	30
Дэлгэрцогт сум	481	461	432	29
Дэлгэрхангай сум	481	438	413	25
Дэрэн сум	539	485	452	33
Сайхан-Овоо сум	481	449	445	4
Хулд сум	481	464	457	7
Лүүс сум	481	478	456	22
Цагаандэлгэр сум	481	447	403	44
өлзийт сум	481	466	445	21
Өндөршил сум	481	475	471	4
Эрдэнэдалай сум	423	411	384	27
Сайнцагаан сум	1081	1067	1034	33

5. Сумын 2020 оны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтээс буурсан үзүүлэлтийг ахиулах тал дээр санаачлага гаргаж ажиллаагүй байна.

6. Аймгийн сайтад Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралтаар батлагдсан ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээлэл оруулах ажил хангалтгүй байна.

7. Засгийн газрын 2020 оны 216, 217, 218 дугаар тогтоол, ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 тушаалаар батлагдсан заавар, аргачлалын цахим сургалтыг ЗГХЭГ-аас зохион байгуулж үүнд 15 сумын 224 албан хаагч хамрагдахаас 13 сумын 204 албан хаагч буюу 91.0 хувь нь хамрагдсан байна. Өлзийт суманд тухайн сургалт зохион байгуулагдсан цаг үед Корона-19 гарсан байсан тул албан хаагчид хамрагдаж чадаагүй. Дэрэн сумын хувьд сургалтад албан хаагчид нь хамрагдсан боловч албан тоотын дагуу мэдээллээ ирүүлээгүй байна. Хулд сум нийт албан хаагчийн 42.8 хувийг хамруулсан нь хангалтгүй байна.

Сургалтад хамрагдсан байдлыг хүснэгтээр харуулбал:

№	Сумын нэр	Хамрагдвал зохих албан хаагчийн тоо	Хамрагдсан албан хаагчийн тоо	Хувь
1	Адаацаг	15	14	93.3
2	Баянжаргалан	14	14	100
3	Говь-Угтаал	14	17	100
4	Гурвансайхан	14	14	100
5	Дэлгэрцогт	15	17	100
6	Дэрэн	14	-	
7	Дэлгэрхангай	15	17	100
8	Өндөршил	15	20	100
9	Өлзийт	15	-	

10	Сайхан-Овоо	15	22	100
11	Сайнцагаан	15	18	100
12	Хулд	14	6	42.8
13	Луус	15	13	86.6
14	Цагаандэлгэр	13	13	100
15	Эрдэнэдалай	21	19	90.4
Нийт		224	204	91

8. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааг тайлагнах хугацаат мэдээ тайлангийн хуваарийн дагуу тайлан мэдээг хугацаанд ирүүлэх асуудал дутагдалтай байна.

Дөрөв. Цаашид анхаарах асуудал, зөвлөмж

Өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг эрчимжүүлэн жилийн эцсээр сум, хэлтэс, агентлагт өгсөн нийтлэг 20 зөвлөмж, тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт үр дүнг тооцон аймгийн Засаг даргатай сумын Засаг даргын байгуулсан гэрээний 7 дугаар хавсралт, аймгийн Засаг даргын А/93 тоот захирамжид заасан хугацаанд ирүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай.

Илтгэх хуудас бичсэн:

Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн  
ахлах мэргэжилтэн Э.Одончимэг